



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 08 дугаар сарын 11 өдөр Дугаар 42

Хэрлэн сум

ХХХХII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 42 дугаар хурал өргөтгөсөн хэлбэрээр 2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 83,3 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт Тамсаг-21 дүгээр талбайгаас Баянхошуу боомт хүртэлх 58,5 км хатуу хучилттай авто замыг барихад шаардагдах цементийг Баянхошуу боомтоор импортоор оруулж ирүүлэх тухай хүсэлтийг хэлэлцэх:

Мэргэжлийн хяналтын газар

2. Газрын тосны тээвэрлэлтийг нэмэгдүүлэх талаар Улсын Онцгой комисс, Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Петровича Дачин Тамсаг ХХК-аас ирүүлсэн хүсэлтийг хэлэлцэх:

Мэргэжлийн хяналтын газар

3. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон-Уул 19 дүгээр талбай дахь тусгаарлах байрны хяналт шалгалт зохион байгуулсан талаарх мэдээлэл

Мэргэжлийн хяналтын газар

4. Тусгаарлалтад байгаа "ДБЭХС" ТӨХК-ийн хүчин чадлыг 50 МВТ-аар нэмэгдүүлж, өргөтгөх төслийн гүйцэтгэгч БНХАУ-ын "ТВЕА" ХХК-ийн 31 иргэнийг гэрийн ажиглалтад шилжүүлэх талаар

Эрүүл мэндийн газар

5. Онцгой комиссын гишүүдийн саналаар нэмж хэлэлцүүлэх асуудлын талаар,

Онцгой комиссын гишүүд

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт Тамсаг-21 дүгээр талбайгаас Баянхошуу боомт хүртэлх 58,5 км хатуу хучилттай авто замыг барихад шаардагдах цементийг Баянхошуу боомтоор импортоор оруулж ирүүлэх тухай тус замын ажлыг гүйцэтгэгч Их Монгол Барилга ХХК-ийн хүсэлт, Улсын Онцгой комиссоос албан бичгээр ирүүлсэн чиглэлийг хэлэлцэж аймгийн Онцгой комиссын гишүүдийн 100 хувийн саналаар холбогдох хууль журам, дүрмийн дагуу урьдчилсан байдлаар цемент импортоор оруулж ирэхийг дэмжсэн.

2. Газрын тосны тээвэрлэлтийг нэмэгдүүлэх талаар Улсын Онцгой комисс, Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Петровичайна Дачин Тамсаг ХХК-аас ирүүлсэн 16 тээврийн хэрэгслээр нэмэгдүүлэх талаар хүсэлтийг аймгийн Онцгой комиссын гишүүдийн 100 хувийн саналаар дэмжив.

Нэг. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын орлогч дарга, Онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Д.Баттулга,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын гишүүн, хурандаа Б.Бямбаа,
Байгаль орчин аялал жуучлалын газрын дарга, Онцгой комиссын гишүүн А.Гантулга,
Халхгол сумын Засаг дарга Сумын Онцгой комиссын дарга Х.Хүрэл-эрдэнэ
Гаалийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Б.Гэрэлт-Од нарт:

1.1. Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлын үеийн хариу арга хэмжээний дэглэмийн хүрээнд “Хилийн авто замын боомтоор улс хоорондын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам”-ын дагуу Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт Тамсаг–21 дүгээр талбайгаас Баянхошуу хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто замын 58,5 км хэсэгт шаардагдах цементийг хилээр оруулахад дэмжлэг үзүүлэхийг,

1.2. Үүнтэй холбогдуулан тус боомтод ажиллах хүн хүч, хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн пункт, халдвар хамгааллын хувцас хэрэгслийг нэмэгдүүлж, бэлэн байдлыг хангуулах ажлын хэсгийг Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Тагнуулын газар, Байгаль, орчин аялал жуучлалын газар, Халхгол сумын Засаг дарга, Гаалийн газрын холбогдох албан тушаалтан нарын бүрэлдэхүүнтэйгээр Аймгийн Засаг даргын орлогчийн удирдамжаар байгуулан ажиллуулахыг,

1.3. Баянхошуу боомтоор цементийг импортоор оруулж ирэх талаар Улсын онцгой комисст албан бичиг хүргүүлэхийг,

Хоёр. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа -д:

2.1. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт Тамсаг–21 дүгээр талбайгаас Баянхошуу хилийн боомт руу газрын тосны тээвэрлэлтийг 16 тээврийн хэрэгслээр нэмэгдүүлж 40 болгохыг,

2.2. “Петровичайна Дачин Тамсаг” ХХК-нд жолооч нарын хариуцлагыг өндөржүүлэх зөвлөмж, зөвлөгөө өгөх талаар албан бичиг хүргүүлэхийг,

Гурав. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа-д

3.1. “Петровичайна Дачин Тамсаг” ХХК-нд ажиллах БНХАУ-ын 46 ажилтны тусгаарлалтын хугацаа дууссаны дараа гэрийн ажиглалтад байлгах 14 хоногийн хугацааг хаана байлгах талаар тодруулж шийдвэрлэхийг,

Дөрөв. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын орлогч дарга, Онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Д.Баттулга,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Д.Мөнхтуяа,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,
“Гадаадын иргэний харъяатын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Д.Төрхүү,
Хэрлэн сумын Засаг даргын орлогч, Онцгой комиссын
гишүүн О.Пүрэв-Очир нарт:

4.1.Тусгаарлалтад байгаа “ДБЭХС” ТӨХК-ийн хүчин чадлыг нэмэгдүүлж, өргөтгөх ажлыг гүйцэтгэх БНХАУ-ын 31 иргэнийг гэрийн ажиглалтад шилжүүлэх байр бэлэн болоогүй учир тусгаарлах байрнаас гаргах боломжгүй байгаа тухай “ТВЕА” ХХК-нд мэдэгдэхийг,

4.2.БНХАУ-ын 31 иргэн өөр байранд гэрийн ажиглалтад шилжүүлэх тохиолдолд Эрүүл мэндийн газраас томилогдсон ажлын хэсэг газар дээр нь шалгаж, хариу мэдэгдэхийг,

4.3.Гар утасны апплейкшний төлбөрийн зардлыг “ТВЕА” ХХК шийдвэрлүүлэх

4.4.Холбогдох зардлыг шийдвэрлүүлэх талаар “ТВЕА” ХХК-ийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, аймгийн Онцгой комиссын 43 дугаар хуралдаанд танилцуулахыг,

Тав. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа-д:

5.1.“Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 20/637 дугаар албан тоотой БНХАУ-аас 56 ажилчин оруулж ирэх хүсэлт ирүүлснийг судалж, нарийн мэргэжил шаардагдахгүй ажилтан ажиллагсдыг аймгаас ажиллуулах боломжтой талаар тусгаж, албан бичиг хүргүүлэхийг,

5.2.Хадлангийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг Баянхошуу боомтоор оруулж ирэх боломжгүй тухай Мэргэжлийн хяналтын газраас иргэн Гарьдад албан бичиг хүргүүлэхийг,

Зургаа. Гадаадын иргэний харъяатын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа-д:

6.1.“Баянхошуу” хилийн боомтод тусгаарлах байр шинээр барих зардлыг шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг Улсын онцгой комисст хүргүүлэхээр тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА

М.БАДАМСҮРЭН

БҮСИЙН ТӨВ ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН
ГАЗРЫН ОРЛОГЧ, ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Д.БАТТУЛГА